



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/215

Хэрлэн сум

Хурдан морины бүсийн уралдаан
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9.3 дахь заалт, Сэцэн Ханы хүлэг морин спорт уяачдын холбооноос ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бүсийн хавар, зуны хурдан морины уралдааныг зохион байгуулах сумдыг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн бүсийн уралдаалга зохион байгуулагдаж буй сумдад уралдаанч хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангуулж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга /Б.Энх-Эрдэнэ/-д, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Б.Сүнгээ/-д тус тус үүрэг болгосугай.

3. Нийтийн хэв журам, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн газрын дарга /Цагдаагийн хурандаа Ж.Болд/-д үүрэг болгосугай.

4. Хурдан морины бүсийн уралдаануудыг зохих хууль, дүрэм журмын дагуу зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга, сумдын уяачдын холбооны тэргүүн, Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-г, "Сэцэн Ханы хүлэг" морин спорт уяачдын холбоо /Т.Батжаргал/-д тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2019 оны
...05... дугаар сарын ...03... өдрийн .../.../...
дугаар захирамжийн хавсралт



**Хурдан морины уралдааныг зохион байгуулах бүсийн сумд,
уяачдын холбоо, хуваарь, насны төрөл**

№	Зохион байгуулах сумд	Он,сар өдөр	Зохион байгуулагдах бүс	Зохион байгуулах насны төрөл	Зохион байгуулах морин спорт уяачдын холбоо
1	Баянхутаг	2019.05.05	Төвийн бүс	Бага 3 нас	"Жаргалант хүлэг"
2	Бор-Өндөр	2019.05.13	Баруун бүс	Бага 3 нас	"Боржигон ажнай"
3	Галшар	2019.05.13	Хойд бүс	Бага 3 нас	"Хардал бэйсийн унага"
4	Батширээт	2019.06.26	Урд бүс	Бага 3 нас	"Ар хөвчийн унага"
5	Биндэр	2019.06.23	Төвийн бүс	Дээд 3 нас	"Найман шарга"
6	Дэлгэрхаан	2019.07.07	Баруун бүс	Дээд 3 нас	"Хөдөө арлын хүлэг"
7	Норовлин	2019.07.07	Зүүн бүс	Дээд 3 нас	"Уран дөш"
8	Өмнөдэлгэр	2019.07.25	Хан Хэнтийн шигшмэл хурд	Азарга, Их нас	"Сэцэн Ханы хүлэг", "Айргийн хүлэг"
9	Баянмөнх	2019.07.04	Өмнөд бүс	Дээд 3 нас	"Мөнхийн хүлэгч"